



ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйл, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний тухай хуулийн 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр компанийн эрхлэх үйл ажиллагаанд нэмэгдсэн заалтуудын дагуу компанийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаанд орсон өөрчлөлтийг компанийн дүрэмд тусгаж, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Ц.Эрдэнэбулган Дэд захирал

Нарийн бичгийн дарга: Д.Амармөнх Хуулийн мэргэжилтэн бөгөөд захирлын туслах

Гишүүд: Г.Балжинням Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий диспетчер
Б.Ганбат Төв диспетчерийн албаны дарга
Б.Төрбат Реле хамгаалалт, автоматикийн албаны дарга
Ч.Энхжаргал Арилжааны зохицуулалтын албаны дарга
Ц.Өнөрмаа Горим төлөвлөлт, тооцооны албаны дарга
Т.Мөнхбаяр Мэдээллийн технологи, холбооны албаны дарга
Б.Баярцэнгэл Ахлах нягтлан бодогч
Д.Алимаа Хүний нөөцийн мэргэжилтэн

2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг 2016 оны 03 дугаар сарын 10-ны дотор багтаан Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ТУЗ-ийн хуралд оруулахыг ажлын хэсэг /Ц.Эрдэнэбулган/-т үүрэг болгосугай.

3. ТУЗ-өөр хэлэлцүүлсэн компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж, батлуулах, батлагдсан дүрмийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэхийг ажлын хэсэг /Ц.Эрдэнэбулган/-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.ЦОГТБААТАР